



АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБА

ДОТООДЫН АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ОСОЛ, ЗӨРЧЛИЙН СУДАЛГАА

2026 оны 01 дүгээр сарын 28

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБА

Хаяг: Хан-Уул дүүрэг 21-р хороо, ИНУТ-ийн байр 101, 105 тоот
Улаанбаатар хот 17120, Монгол Улс
Утас/Факс: 71-285011, 71-285040 / (+976)-70049974
Веб хаяг: www.aaib.gov.mn,
имэйл: aaib@aaib.gov.mn

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсын Иргэний Нисэхийн салбар жил ирэх бүр эрчим тэй хөгжиж байгаа бөгөөд уул уурхайн үйлдвэрлэл, аялал жуулчлалын салбартай уялдан ачаа, зорчигч эргэлтийн өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг дагаад агаарын тээвэрлэгч компаниуд агаарын хөлгийн паркийн хүчин чадлаа нэмэгдүүлж, орон нутагт төдийгүй олон улсад өрсөлдөх чадвараа сайжруулсаар байна.

“Изинис Эйрвэйз” ХХК 2019 оны 02 дугаар сарын 20-нд үйл ажиллагаагаа дахин сэргээж B737-700 EI-ULN, B737-7K2 EI-GVW бүртгэлийн дугаартай 2, A330-202 JU1332 бүртгэлийн дугаартай агаарын хөлгөөр нислэг үйлдэж байна.

Монгол улсад B767-300 агаарын хөлөг-1, B737-800 -3, B737-8 MAX-1, B737-700 -2, B787-9 -2, B757-222 -1, CL-6002C10 агаарын хөлөг-1, Embraer ERJ190-100LR агаарын хөлөг -2, A319-112 -1, A319-115 -1, A330-202 -1, A320-214 агаарын хөлөг-1, (Бусад – Ми-8АМТ-1, Ми-8МТВ-1, Ми-26Т-1, CESSNA 208В-6, Airbus EC130Т2-1, Airtrac tor АТ602 -1, AS350 В3е-3, МВВ-ВК117 D3-3, МВВ-ВК117С2-1, С 172S-1, хэт хөнгөн STOL-СН801 HD агаарын хөлөг -1) зэрэг агаарын хөлгүүд ашиглагдаж байна.

Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй 10 агаарын тээвэрлэгчээс төрийн өмчит “МИАТ” ХК - 9 (4-нь Ирланд улсад бүртгэлтэй), хувийн хэвшлийн “Аэромонголиа” ХХК -2, ”Хүннү Эйр” ХХК -3, “Изинис Эйрвэйз ХХК-3, “Геосан” ХХК-4, “Скай Жет” ХХК-2, “Томас Эйр” ХХК-1, “Тэнгэрийн улаач Шинэ” ХХК-1, “Монголиан Эйрвэйз Карго” ХХК-1, “Монголын Нисэхийн Академи” ХХК-1, “Альфа Аврора Эвиэйшн” ХХК-5, “Зорт Эйр” ХХК-3, "А-Жет Авиэйшн" ХХК-1, “Оранж Эйр” ХХК-1, Иргэн Сүхбаатар Болд баатар хэт хөнгөн -1, нийт 38 агаарын хөлгөөр үйл ажиллагаа явуулж байна.

Дараах агаарын тээвэрлэгчээс “Хүннү Эйр” ХХК-1, “Монголиан Эйрвэйз Карго” ХХК-1, “А-Жет Авэйшн” ХХК-2, “Монголиан Эйрвэйз” ХХК-3, “Геосан” ХХК-3, “Топ Экстрим Экшин Монголиа” ХХК-4, “Сэлиэр Авиэйшн Монголиа” ХХК-1, “Континентал Эйр” ХХК-1, “Залуу бүргэд Женерал Авэйшн” ХХК-1,

“Скай хаукс” ХХК-1, “Аэрохели” ХХК-1, “Нью Клеос” ХХК-4, “Медика Монголиа” ХХК-1 тус тус бүртгэлтэй агаарын хөлөгтэй, “Сатурн Экстрем Монголиа” ХХК-1 Халуун бөмбөлөгтэй байна.

Хувь хүний нэр дээр 3 нийт 23 агаарын хөлөг Монгол улсад бүртгэлтэй байна. /НААХЗА-с авсан мэдээллээр/

Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны судалгаагаар агаарын тээвэрлэгч байгууллагууд тэдгээрийн агаарын хөлөгтэй холбоотой осол, ноцтой зөрчил болон зөрчил 2021 - 2025 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 189 тохиолдол бүртгэгдсэн байна. Үүнд:

- Осол – 3
- Ноцтой зөрчил – 2
- Зөрчил, дутагдал –184

Тус албанаас дээрхи онуудад агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгасан 16 тайлан, нислэгийн аюулгүй ажиллагаатай холбоотой 59 зөвлөмж гаргасан байна.

Осол, зөрчлийн статистикийг ангилж 1 дүгээр графикт “Осол болон Ноцтой зөрчлүүд”, 2-4 дүгээр графикт “Аюулгүй ажиллагаатай холбоотой” зөрчлүүд, 5-6 дугаар графикт “Авиа компани болон агаарын хөлөгтэй” холбоотой зөрчлүүд, 7-9 дүгээр графикт шувуутай холбоотой зөрчлүүд, 10-15 дугаар графикт, мөн зөвлөмжтэй холбоотой статистикуыг орууллаа.


АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ОСОЛ, ЗӨРЧЛИЙН СУДАЛГАА



| Д/Д | Он | Осол | Ноцтой зөрчил | Зөрчил | Нийт тохиолдол | Шинжлэн шалгасан тайлан | Аюулгүй байдлын зөвлөмж | Шувуутай холбоотой зөрчил |
|-----|-------------|------|---------------|--------|----------------|-------------------------|-------------------------|---------------------------|
| 1 | 2021 | 0 | 0 | 25 | 25 | 6 | 14 | 8 |
| 2 | 2022 | 1 | 0 | 48 | 49 | 2 | 10 | 30 |
| 3 | 2023 | 0 | 0 | 38 | 38 | 2 | 13 | 15 |
| 4 | 2024 | 1 | 1 | 33 | 35 | 4 | 11 | 8 |
| 5 | 2025 | 1 | 1 | 40 | 42 | 3 | 5 | 12 |
| 6 | Нийт | 3 | 2 | 184 | 189 | 17 | 53 | 73 |

График 1: Осол болон ноцтой зөрчлийн тоо /2021-2025/

2021-2025 онд гарсан осол, ноцтой зөрчил



Зөвлөмж



Зөрчлийн талаар.

Агаарын хөлгийн нислэгийн үед тохиолдсон зөрчлүүдийг мэдээллийн дагуу бүртгэгдсэн байдлаар ангилж үзэхэд:




| № | Ангилал | Оноор | | | | | Нийт |
|-----------|---|-----------|-----------|-----------|-----------|-----------|------------|
| | | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 | |
| 1 | Агаарын хөлгийн хөдөлгүүр унтарсан | - | - | - | - | - | - |
| 2 | Хөдөлгүүр, туслах хөдөлгүүртэй холбогдолтой | 1 | 1 | - | 1 | - | 3 |
| 3 | Агаарын хөлгийн техник, эд ангийн ажиллагаатай холбогдолтой | 1 | 7 | 6 | 1 | 5 | 20 |
| 4 | Тасалдсан хөөрөлт үйлдсэн | 1 | 1 | - | - | - | 2 |
| 5 | Хүний хүчин зүйл | 3 | - | - | - | - | 3 |
| 6 | Битүүмжлэл алдагдах | 1 | - | - | 1 | - | 2 |
| 7 | Дугуй болон түүний эд ангитай холбогдолтой | 2 | 3 | - | 3 | 3 | 11 |
| 8 | Ойртолт | - | - | - | - | - | - |
| 9 | Шувуутай холбогдолтой | 8 | 30 | 15 | 8 | 12 | 73 |
| 10 | 2-р тойрог нислэгт гарсан | 2 | 5 | 13 | 19 | 18 | 57 |
| 11 | Цаг агаартай холбогдолтой | - | - | - | - | - | - |
| 12 | Нислэгийн холбоо барих | - | 1 | - | - | - | 1 |
| 13 | Нислэгийн зөвшөөрөл | - | - | - | - | - | - |
| 14 | НХУдирдлагын тоног төхөөрөмжтэй холбогдолтой | 2 | - | - | - | - | 2 |
| 15 | Хилийн бүсэд нислэг үйлдсэн | 1 | - | - | - | - | 1 |
| 16 | Аянганд цохиулсан | - | - | 1 | - | - | 1 |
| 17 | Цонхны шил цуурах | 1 | - | - | - | 1 | 2 |
| 18 | Гадны биетээс | - | - | - | - | 1 | 1 |
| 19 | Бусад | 2 | - | 3 | - | - | 5 |
| 20 | Нийт | 25 | 48 | 38 | 33 | 40 | 184 |

❖ График 2: Зөрчлийг шалтгаанаар ангилвал /2021-2025/

Өнгөрсөн 5 жилд гарсан нийт 184 зөрчлийг шалтгаанаар нь тодорхойлвол Техникийн дутагдалтай холбоотой 20 зөрчил бүртгэгдсэн нь нийт зөрчлийн 10,86%, Шувуутай холбоотой зөрчил 73 буюу 39,67%, 2-р тойрогт гарсан зөрчил 57 буюу 30,97% -ийг эзэлж байна.


❖ 2021-2025 онд




❖ График 3: Зөрчлийг нислэгийн үе шатаар ангилвал /2021-2025/

2021-2025 онд бүртгэгдсэн зөрчлийг зөвхөн нислэгийн үе шатаар ангилвал нийт 184 зөрчил бүртгэгдсэнээс Газарт/зогсоолд-9 буюу нийт зөрчлийн 4,8%-ийг, Явгалалт - 4 буюу 2,17%-ийг, Хөөрөлт-24 буюу 13,04%-ийг, Нислэгт-11 буюу 5,97%-ийг, Буултын үед-91 зөрчил гарсан нь нийт зөрчлийн 49,45% -ийг эзэлж байна.

❖ 2021-2025 онд



❖ График 4: Зөрчлийг сараар ангилвал /2021-2025/




Дээрхи графикт 2021-2025 онуудад гарсан аюулгүй ажиллагаатай холбоотой зөрчлүүдийг нэгтгэн сар түс бүрээр ангилсан бөгөөд сүүлийн 5 жилийн дунджийг харвал 1, 2, 6 болон 8, 11 дугаар сард бүрт гэгдсэн зөрчлийн тоо бусад сараасаа илүү байгаа нь тухайн сард түлхүү анхаарч аюулгүй ажиллагааг хангуулах, урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгуулах шаардлагатай харагдаж байна.(Сүүлийн 5 жилд гарсан зөрчлийн тоо бага байгаа нь Корона вирусийн халдварт цар тахалтай холбоотой.)


❖ График 5: Авиа компаниудын осол зөрчлийн тоо /2021-2025/



Манай улсад нислэг үйлдэж байгаа агаарын тээвэрлэгч байгууллагуудын зөрчлийн бүртгэлийг сүүлийн 5 жилээр харвал нийт 184 зөрчил дутагдал бүртгэгдсэн байгаагаас МИАТ компанитай холбоотой 69 зөрчил дутагдал буюу /37,5%/, Аэромонголиа 33 буюу /17,93%/, Хүннү Эйр 6 буюу /3,26%/, Изинис 10 буюу /5,43 %/, Бусад 45 /Гадаадын агаарын тээвэрлэгчид/ буюу /24,45%-ийг эзэлж байна.



❖ График 6: Агаарын хөлгийн маягаар ангилсан осол, зөрчлийн тоо /2021-2025/




2021-2025 онд агаарын хөлөгтэй холбоотой нийт 184 зөрчил бүртгэгдсэн байгаагаас Boeing агаарын хөлөгтэй холбоотой зөрчил - 74 байгаа нь нийт зөрчлийн /40.21%, A319 агаарын хөлөгтэй холбоотой зөрчил - 16 /8.69%, Embraer агаарын хөлөгтэй холбоотой зөрчил – 23 /12.5%, A330 агаарын хөлөгтэй холбоотой зөрчил -24 /13.04 %, CRJ агаарын хөлөгтэй холбоотой зөрчил 8 /4.34%, бусад буюу /F50, A320, ATR42, ATR72, EC145, PC6, H125 CESSNA-208, AS350 B3, Safari LSA/ зэрэг агаарын хөлөгтэй холбоотой зөрчлүүд -26 байгаа нь нийт зөрчлийн 14.1% хувийг эзэлж байна.

ШУВУУТАЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧЛИЙН СТАТИСТИК

Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны судалгаагаар агаарын хөлөг шувуутай мөргөлдсөн тохиолдол 2021-2025 онд нийт 73 (Улаан баатар хотод /Буянт-Ухаа-д -8, Чингис хаан-д -10/ -18, Орон нутагт -7, Хан бумбат НБ - д -27, Гадаад улсад -17) бүртгэгдсэн байна.


График №7: Шувуутай холбоотой зөрчлийг байршил болон оноор




Сүүлийн 5 жилийн хугацаанд шувуутай холбоотой 73 зөрчил бүртгэгдэж нийт зөрчлийн 39.67% - ийг эзэлж байгаа нь нислэгийн давтамж болон агаарын тээвэрлэгч байгууллагууд тэдгээрийн агаарын хөлгүүд нэмэгдсэнтэй холбоотой байна.

График №8: Шувуутай холбоотой зөрчлийг нислэгийн үе шатаар ангилвал /2021-2025/

Нийт 73 шувуутай холбоотой зөрчлийг нислэгийн үе шатаар ангилвал “Буултын ” үед 46 зөрчил буюу нийт зөрчлийн 63.01% хувийг, “Хөөрөлтийн” үед 16 буюу 21.91% хувийг, ойртолтын үед 8 буюу 10.95%-ийг тус тус эзэлж байна.



Шувуутай холбоотой зөрчлүүдийг сараар ангилвал /2021-2025/



Дээрх графикт шувуутай мөргөлдсөн тохиолдлыг сар түс бүрээр ангилсан бөгөөд жилийн дунджийг харвал 1, 4, 5 болон 8, 10 дугаар сард бүртгэгдсэн зөрчлийн тоо бусад саруудаас илүү байна.

Чингис Хаан ОУНБуудал түүний орчимд 83 зүйл шувуу тохиолдох ба үүний 27% буюу 22 зүйл нь суурин, 73% буюу 61 зүйл нь нүүдлийн амьдралтай шувууд байна.


ЗӨВЛӨМЖТЭЙ ХОЛБООТОЙ СТАТИСТИК




Тус албанаас 2021-2025 оны хооронд аюулгүй ажиллагаатай холбоотой нийт 53 зөвлөмж гаргасан байна . Доорх графикт Агаарын тээвэрлэгч байгууллагууд, Иргэний нисэхийн ерөнхий газарт, болон Шувуутай холбоотой гаргасан зөвлөмжүүдийг он тус бүрээр нь оруулсан болно.

◆ График 10: Аюулгүй байдлын зөвлөмжийн статистик /2021-2025/ ◆ График 11: Аюулгүй байдлын зөвлөмжийн статистик /2021-2025/

Зөвлөмж өгсөн байгууллагууд




Агаарын тээвэрлэгч байгууллагууд




❖ График 12: Аюулгүй байдлын зөвлөмжийн ангилал /2021-2025/

Өнгөрсөн 2021-2025 онуудад осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан аюулгүй байдлын зөвлөмжийг холбогдох хэсгээр нь ангилвал нийт 53 зөвлөмжийн 12-нь Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний аюулгүй ажиллагаатай холбоотой, 7-нь Сургалттай холбоотой, 8-нь шуугуйтай холбоотой аюулгүй байдлын зөвлөмжүүд гаргасан байна.




❖ График 13: Аюулгүй байдлын зөвлөмжийн биелэлт /2021-2025/

Мөн дээрх онуудад гарсан аюулгүй байдлын зөвлөмжийн биелэлтийг сүүлийн 5 жилээр харвал нийт 53 зөвлөмж гаргаснаас Хэрэгжсэн -34 / 64.15%, Хэрэгжих шатандаа -11 /20.75%, Хэрэгжээгүй 7 /13.2%, шаардлагагүй зөвлөмж 1 байна.



❖ График 16: Хамтран ажилласан гадаадын байгууллагууд /2018-2025/

Дээрх онуудад гаргасан тайлан, зөвлөмжийг дараах улсуудын шинжлэн шалгах байгууллагуудтай (ОХУ-IAC, АНУ-NTSB, Франц-BEA, Ирланд-AAIU, Канад-TSB, Англи- AAIBBranch, Хятад-CAAC, Солонгос-ARIAВ, Сингапур-AAIB), мөн АНУ-ын Воеинг компани, ХБНГУ-ын Люфтханз компани, ИКАО болон Олон улсын шинжээчдийн нийгэмлэг (ISASI) зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж гаргасан болно.



❖ График 17: MOU байгуулсан гадаадын шинжлэн шалгах байгууллагууд /2007-2025/

Гадаад улсаас монгол улсад нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн харьяалах орны шинжлэн шалгах байгууллагуудтай Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах ажлыг 2007 оноос эхлүүлж ОХУ, БНСУ, БНФУ-тай байгуулсан байна. 2013 оноос БНХАУ, Канад, Сингапур, БНАСАУ, Япон, Казакстан улсуудын шинжлэн шалгах байгууллагатай MOU байгуулан ажиллаж байна. 2009 онд ОХУ-IAC -тай байгуулсан Санамж бичгийг 2024.02.01-ний өдөр Улаанбаатарт дахин шинэчлэн гарын үсэг зурж баталгаажуулсан.

Олон улсын хамтын ажиллагаа

| List of MOUs | Country | Agency | Year |
|--------------|---------|--------|------------|
| France | BEA | | 2010 |
| Russia | IAC | | 2009, 2024 |
| South Korea | | | 2007 |
| China | CAAC | | 2013 |
| Canada | TSB | | 2013 |
| Singapore | AAIB | | 2014 |
| DPR Korea | GACA | | 2015 |
| Japan | JTSB | | 2017 |
| Kazakhstan | | | 2018 |

2011 онд Олон улсын шинжээч нарын нийгэмлэгт гишүүнээр элсэн орсон

Дотоодын хамтын ажиллагаа



Хамтран ажиллаж байгаа байгууллагууд

Иргэний нисэхийн ерөнхий газар

МИАТ ТӨХК

Иргэний нисэхийн үндэсний төв

Изинис Эйрвэйз ХХК

Онцгой байдлын ерөнхий газар

Хүннү Эйр ХХК

Цагдаагийн ерөнхий газар

Альфа Аврора Эвиэйшн ХХК

Шүүх шинжилгээний ерөнхий газар

Монголын агаарын тээврийн нисгэгчдийн холбоо

Тээврийн прокурор

Сүүлийн 5 жилийн нийт нислэгийн гүйцэтгэлийн харьцуулалт

| № | Нислэгийн төрөл | I-XII сарын нислэгийн гүйцэтгэл | | | | | 2021 оныг 2025 онойг харьцуулахад өссөн | |
|---|--|---------------------------------|---------------|--------------|--------------|---------------|---|---------------|
| | | 2021 он | 2022 он | 2023 он | 2024 он | 2025 он | тоо | хувь |
| 1 | Олон улсын өнгөрөлт | 68715 | 37565 | 16961 | 67823 | 81086 | 68715 | 81086 |
| | Өмнөх оноос өссөн хувь | -3.8 | -45.3 | -45.3 | 74.9 | 19.55 | 12371 | 18.0 |
| 2 | Олон улсын хөөрөлт,буулт | 2435 | 5334 | 5334 | 12990 | 15352 | 2435 | 15352 |
| | Өмнөх оноос өссөн хувь | 29.3 | 54.3 | 54.3 | 69.9 | 18.1 | 12917 | |
| 3 | Орон нутгийн хөөрөлт,буулт | 4663 | 8819 | 8819 | 10968 | 12228 | 4663 | 12228 |
| | Өмнөх оноос өссөн хувь | -16.1 | 47.1 | 47.1 | 62.47 | 11.48 | 7565 | |
| | Нийт нислэгийн дүн: | 75813 | 51718 | 51718 | 91781 | 108666 | 75813 | 108666 |
| | Нийт нислэгийн өмнөх оноос өссөн хувь | -3.84 | -46.58 | 0 | 77.46 | 18.39 | 32853 | 44.3 |
| | Есэлтийн дундаж хувь | | | 9.08 | | | | |

Сүүлийн 5 жилийн нийт нислэг



Сүүлийн жилүүдэд 40 улсын 161 авиакомпаний агаарын хөлгүүд манай улсын нутаг дэвсгэр дээгүүр Олон улсын өнгөрөлтийн болон буулт, хөөрөлтийн тогтмол хуваарийн, цагийн хуваарийн бус нислэг үйлдэж байна.

АХОЗШША-ны гаргасан тайлан, зөвлөмжид хяналт тавих, хэрэгжүүлэх талаар ИКАО-ын Annex 13, Иргэний нисэхийн тухай Монгол улсын хууль.



Чикагогийн конвенцийн Хавсралт 13-ын бүлэг 7:

7.4 *The Preliminary Report shall be sent by facsimile, e-mail, or air mail within **thirty days** of the date of the accident unless the Accident/ Incident Data Report has been sent by that time. When matters directly affecting safety are involved, it shall be sent as soon as the information is available and by the most suitable and quickest means available.*

6.3 *If the State conducting the investigation receives comments within **sixty days** of the date of the transmittal letter, it shall either amend the draft Final Report to include the substance of the comments received or, if desired by the State that provided comments, append the comments to the Final Report. If the State conducting the investigation receives no comments within sixty days of the date of the first transmittal letter, it shall issue the Final Report in accordance with 6.4, unless an extension of that period has been agreed by the States concerned.*

6.5 *In the interest of accident prevention, the State conducting the investigation of an accident or incident shall make the Final Report publicly available as soon as possible and, if possible, within **twelve months**.*

6.6 *If the report cannot be made publicly available within **twelve months**, the State conducting the investigation shall make an interim statement publicly available on each anniversary of the occurrence, detailing the progress of the investigation and any safety issues raised*

Алба нь Монгол улсын нутаг дэвсгэрт гарсан агаарын хөлгийн осол, зөрчлийг гарсан өдрөөс хойш **30 өдөрт** багтаан урьдчилсан тайланг гаргах ба аюулгүй ажиллагаанд шууд нөлөөлж болзошгүй байвал урьдчилсан тайланг аль болох яаралтай гаргаж дараах улсын эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ

Алба нь агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгасан эцсийн тайлангийн төслийг бүртгэсэн улс, тээвэрлэгчийн харьяал ах улс, зохион бүтээсэн улс, үйлдвэрлэсэн улсад, мөн шинжлэн шалгах ажиллагаанд оролцсон улс орнуудад илгээх бөгөөд албан бичгийг илгээсэн өдрөөс хойш **60 өдөрт** багтаан санал хүлээн авах нөхцөлийг бүрдүүлнэ.

Алба нь тайлангийн төсөл илгээсэн улсуудаас саналыг хүлээн авч, хүлээн авсан саналын агуулгыг тусгахын тулд эцсийн тайлангийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

Алба нь аль болох богино хугацаанд эцсийн тайланг гаргах ба хэрэв боломжтой бол осол гарсан өдрөөс хойш **12 сард** багтаан гаргана. Хэрэв тайланг **12 сард** багтаан гаргах боломжгүй бол шинжлэн шалгах ажлын явц, гаргаж тавьсан аливаа аюулгүй байдлын асуудлыг нарийвчлан харуулсан дотоодын тайлан болон явцын мэдэгдэл гаргана.

АХОЗШША-ны гаргасан тайлан, зөвлөмжид хяналт тавих, хэрэгжүүлэх талаар ИКАО-ын Annex 13, Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуульд



Чикагогийн конвенцийн Хавсралт 13-ын бүлэг 6:

**RESPONSIBILITY OF A STATE RECEIVING OR ISSUING SAFETY
RECOMMENDATIONS**

Action on safety recommendations

6.10 A State that receives safety recommendations shall inform the proposing State, within **ninety** days of the date of the transmittal correspondence, of the preventive action taken or under consideration, or the reasons why no action will be taken.

Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуулийн 9-р бүлгийн 47-р зүйлийн:

47.3. Аюулгүй байдлын зөвлөмжийг хүлээн авсан этгээд зөвлөмжийн дагуу шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн 90 хоногийн дотор эргэж мэдэгдэх бөгөөд хэрэгжүүлэх боломжгүй бол үндэслэл бүхий тайлбарыг гаргаж хүргүүлнэ.

47.4. Энэ хуулийн 47.3-т заасан этгээд аюулгүй байдлын зөвлөмжийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь хүлээн зөвшөөрөхгүй байх бодит үндэслэл байгаа бол тайлбарыг агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагад нэн даруй хүргүүлнэ.



Анхаарал тавьсанд баярлалаа.